

## ТАРНИЙН МӨН ЧАНАР

*Б.Оюунчимэг \Ph.D\ Санхүү эдийн засгийн дээд сургууль МУИС*

**Түлхүүр үг:** тарни, тарнийн мөн чанар, утга, хүч, сэтгэл, сэтгэлийн хүч, үг, үгийн эрчим хүч, долгион, резонанс.

**Товч агуулга:** Тарнин утга учир, хүч чдал, тарнийг уншигч хүний сэтгэлийн хүч, итгэл үнэмшил, тарнийн ач тус, тарнийг хэрхэн ойлгож унших арга, тарнийг мөн чанарыгн талаар өгүүлнэ.

Найман настай хүүхдээс наян настай хөгшид хүртэл хагас дуту, буруу хазгай ч болов ямар нэг хэмжээгээр тарни мэдэхгүй монгол хүн байхгүй гэж хэлж болох байх. Нэгэнт бид тарни хэмээх зүйлийг хэрэглэдгээс хойш түүний талаар тодорхой мэдлэгтэй байж, мөн чанарыг нь ухааран ойлгож, түүнд зохих ёсоор хандаж, зөв хэрэглэж сурах хэрэгтэй юм.

“Тарни” нь сэтгэлийн дэс дараалсан, тасралтгүй урсгал гэсэн утгатай үг.

Тарни нь заавал санскрит хэлээр уншдаг, их бага хэмжээтэй, аливаа хүслийг бүтээхэд зориулагдсан уншлага. Тарнийн утга алдагдана гэж үздэг тул орчуулдаггүй аж. Тарни нь дамжин түгж байдаг ариун үгс, авианууд юм. Эдгээрээс гарах чичирхийлэл, долгион нь дээд орон зайн сэтгэлийн догдлолыг үүсгэж, увидас хүч нээдэг байна. Тарни унших нь хоолойноос гарах авиагаар үйлдэх дасгал төдий зүйл биш гэдгийг ойлгууштай.

Тарнийн хүч хэрхэн нөлөөлөх нь уншлагын хэмнэл, яруу дуудлага, итгэл үнэмшил, бишрэл хүндэтгэл, сэтгэлдээ ургуулан бодох, зураглах байдал зэргээс шалтгаалдаг байна. Буддагийн болон бусад их багш нарын сэтгэлийн их хүч тарнид шингэсэн байдаг гэж үздэг ч тарнийг амьдруулагч, увидасыг нь бүрдүүлэгч гол хүч нь тарни унши өөрөө юм. Итгэл, бишрэлгүй, сэтгэлээ боловсруулж захиран төвлөрүүлж чадахгүй бол, сэтгэлийн хүч тэнхээгүй бол тарнийн хүч, ивээлийг горьдолтгүй.

Тарнийг элдэв зүйлд бодол санаагаа сатааруулалгүй, сэтгэл зүрхний гүнээс зохистойгоор уншиж байж ачыг нь үзнэ. Тарнийн хүчээр хүн сэтгэл сарниулах зүйлсээс ангид байж, өөрийн дотоод жинхэнэ билиг оюунтайгаа хялбархан холбоо тогтоож чадна. Сэтгэлийн энгийн түвшингийн ерөнхий байгууламж гадны цочроогч болох өчүүхэн боловч зүйлд (дуу чимээ, үнэр, амт, өнгө үзэмж гэх мэт) сарнин сатаарах нь хялбар бөгөөд энэ нь сэтгэл санаагаа төвлөрүүлэхэд саад тотгор болдог. Тарни унших үед сэтгэлийн хөдөлгөөнөө барьж, тайван амгалан байх ёстой. Тарнийг өвдсөн хүмүүст эмчилгээ болгож, сэтгэл санаа нь тогтворгүй байгаа, бухимдаж шаналсан хүмүүсийг тайвшруулахад хэрэглэдэг.

Буддын сургаал нь хэл шинжлэлийн чиглэлээр гүн гүнзгий үзэл баримтлалтай онол бөгөөд хэл ба сэтгэлийн харилцаа холбооны учир утгыг судалсны үндсэн дээр хэлээр дамжуулан сэтгэлийг засах арга ухааныг боловсруулжээ. Тарни үүний нэг тод жишээ бөгөөд хүний сэтгэлийг өөрчлөх, зовлон зүдгүүрийг засах олон тарни байдаг.

Тарни унших үйл нь сэтгэлийн мөн чанарт суурилдаг бөгөөд түүнийг хүн өөрийн бодол санаагаа нэг зүгт төвлөрүүлж, дотоод хүчээ нэгтгэн зангидах замаар үйлдэх нь үр дүнтэй гэж үздэг.

Тарнийн үг, үсэг бүр эрчим хүчийг агуулдаг байна. Үг, түүний эрчим хүчийг олон улсын эрдэмтэн судлаачид судалсаар ирж. Японы эрдэмтэн, доктор Масару Эмото энэ талын судалгааг доривтой явуулсан хүмүүсийн нэг. Энгийн хүмүүс ч үгийн хүчийг амьдралаараа үзэж баталсан жишээ цөөнгүй байдаг.

Үг нь зөвхөн авиа төдийгүй цахилгаан соронзон долгион юм гэж өнөөгийн шинжлэх ухаан тодорхойлж байна. Физикийн шинжлэх ухаан том, жижиг биетүүдийн хэлбэлзлийн эрчим хүч хатуу, шингэн, хийн төлөвт биетийн дотор түгэн тарах үзэгдлийг долгион, нэг бүтэн хэлбэлзэх хугацаанд хэлбэлзлийн эрчим хүч тархах зайг долгионы урт гэдэг. Биетүүдийн хэлбэлзлийн хэмнэл адил байвал эрчим хүчний долгионууд нь дайралдахдаа улам их эрч хүч, чадалтай болох үзэгдлийг физикт резонанс гэж нэрлэдэг. Олон хүн цуглаж, хамтдаа тарни унших үед энэ үзэгдлийг ажилгагддаг. Хүмүүс энэ хуулийг мэддэг, ашигласан тохиолдолууд ч байдаг. Монголчууд хүчирхэг байх цагтаа Японы арлыг эзлэхээр хэдэнтэй санаархсан, хамгийн сүүлийн удаа хөлөг онгоцтойгоо сүйрсэн түүхтэй. Япончууд олноороо цуглаж, монголчуудын хөлийг эх нутагтаа тавиулахгүй байхыг хүсэж тарни уншиж, далай их шуурга босгон тэднийг хөөж чадсан байдаг. Энэ бол тарни, тарнийн үгийн резонанс үзэгдлийн хүч чадлын жишээ юм.

Үг хүний итгэл, хүслээр улам хүчтэй болдог. Үгийн эрчим хүч, давтамж, хэлбэлзлэл хүчтэй тархаж, дотоод ухамсрын дагуу ажиллаж, хүний мьдралд нөлөөлдөг.

Тарнийн мөн чанарыг ойлгож, утга учрыг ухаарсны дараа уншваас хүчийг нь үзэхэд хялбар болно. Олон тарниас УМ МА НИ БАД МЕ ХУМ хэмээх зүрхэн тарнийн утгын тайлбарыг жишээ болгоё.

“Маанийн түүх” хэмээгч сударт Жанрайсигийн тарни болох УМ МА НИ БАД МЕ ХУМ-ыг жаргал, цэцэглэн мандалт, эрдэм бүхний үндэс, сансраас чөлөөлөгдөхийн арга зэвсэг гэсэн байдаг. Жанрайсиг гэдэг нь “доош харагч” гэсэн утгатай түвэд үг аж. Буриадад Арьяабал гэж нэрлэдэг.

Жанрайсиг (Авлокитэшвара) нь зовсон бүхнийг энэрэн аврах гэсэн Буддагийн нинжин сэтгэлийг төлөөлөн илэрхийлэгч аж. Жанрайсигийг сансрын зовлонгоос гэтлэх маш их бололцоотой хүний ертөнцөд мунхагийн тоосоор нүд нь бүрхэгдсэн нэгний замыг заахын тулд нигүүлсэнгүйн сэтгэлийн аягыг гартаа барьсан Будда Шагжамунийн дүрээр дүрсэлдэг байна. Ташрамд өгүүлэхэд, сансар гэдэг нь төөрөлдөл, төрөл дамжих, орчлонгийн эргэлт гэсэн утгатай үг. Үйлийн үр, сэтгэлийн гэм (нисванис)-ийн эрхээр дээр дурдсан амьдралын зургаан зүйлийн төрөл төдийд эргэх ертөнцийг сансар гэж ойлгож болно.

Буддын сургаалын хураангуй нь энэ тарнид багтдаг. Энэ тарнийн гүн гүнзгий утгыг ойлгох нь нэн чухаг. Судалж, таниж мэдсэн, ойлгож ухаарсан бүх сургаалыг энэ тарнид базан багтааж уншиж сурах зорилго тавиуштай.

Тарни зургаан нийлэмж үсгүүдээс бүтэснийн учир нь билгийн чанад хязгаарт хүрсэн зургаан барамидийн утгыг агуулдагт оршдог. Гэгээрэл ухаарлын замаар туйлбартай, эргэлт буцалтгүй явбаас өнөөгийн хүмүүс бид ирээдүйн хүмүүсийн гоц, чанд чанарт хүрч болох аж. Үүнийг билиг барамид буюу билгийн хэмээн нэрлэж, өнөөгийн хүний оюун ухааны хязгаарын цаана гарсан оюун ухаан гэж ойлгодог аж. Оюун ухаан нь төрөлжсөн байдлаар өглөг өгөх барамид буюу харамгүй сэтгэл, шагшаабад барамид буюу ёс сахихын чанад хязгаарт хүрсэн бодь сэтгэл, хүлцэнгүйн барамид буюу хүлээцийн чанад хязгаарт хүрсэн бодь сэтгэл, хичээнгүйн барамид буюу сайн үйлийг бүтээх хязгаарын чанад хүрсэн бодь сэтгэл, дияан барамид буюу хязгаарын чанад гарсан бясалгал, сэтгэхүй, тэр бясалгалаар бий болох хязгаарын чанад гарсан гоц эрч хүч, чадал, эрдэм увидас, билиг барамид буюу хязгаарыг давж гарсан оюун ухаан гэсэн зургаан шатыг дамжин хөгжиж, оргилдоо хүрнэ хэмээн үздэг.

Харин зургаан нийлэмж үсгүүдийн зэрэглэл нь тэнгэр, асури, хүн, адгуус, бирд, тамын гэсэн амьдралын зургаан хэлбэртэй холбоотой аж.

Эхний УМ нь А, У, М гэсэн гурван авианаас бүтдэг. Эдгээр нь Буддагийн зарлиг, лагшин,

таалал хийгээд мөрөөр замнагчийн ариун бус бие, хэл, сэтгэлийг бэлэгдэнэ. Тарнийг уншихдаа Буддагийн зарлиг, лагшин, таалал нь хязгааргүй хүч гэрлийн хэлбэрээр их амгаланг өгч, буруу үзэл бодол, муу бүхнийг устгаж, бие, хэл, сэтгэлийг ариусгаж байна гэж төсөөлнө. “Буддагийн зарлиг” гэдэг нь түүний өөрийн аман айлдварууд, “лагшин” гэдэг нь түүний бие, “таалал” гэдэг нь түүний үзэл санаа, оюун билиг юм гэж ойлгох нь зөв юм.

Бүх “Бурхад” бидний адил төрөлхтөн байгаад гэгээрлийн зам мөрөөр замнаж, гэгээрч чадсан хүмүүс юм. Тэдний хэн нь ч анхнаасаа л бүх эрдмүүдийг эзэмшсэн, гэмт үйлийг огт үйлдээгүй нэгэн байгаагүй, харин бага багаар ариун бусыг гээж, ариунд хувирснаар ариун бие, хэл, сэтгэлийн хөгжил дэвшилд хүрчээ. Үүнийг хэрхэн үйлдэх зам мөрийг тарнийн дараачийн дөрвөн нийлэмж үсгүүд бэлэгддэг. **МАНИ** гэдэг нь эрдэнэ гэсэн утгатай бөгөөд бусдын тусын тулд гэгээрэлд хүрэхийн арга болох энэрэн нигүүлсэхүй болон асрал хайрыг бэлэгдэнэ. Чандмань эрдэнэ хоосон ядууг үгүй болгодогийн адилаар бусдын төлөө гэсэн сэтгэл зовлон зүдгүүрээс ангижруулна. Бусдын тусын тулд гэгээрэх гэсэн сэтгэл нь хамаг амьтны хүслийг хангагч эрдэнэ юм хэмээн ойлгоно.

**БАДМЕ** гэсэн дараагийн нийлэмж үсгүүд нь лянхуа буюу ариун гарвалт гэсэн утгатай бөгөөд билиг оюуныг бэлэгдэнэ. Шавар балчигнаас ургадаг лянхуа цэцэг шаврын цөвөөр гундан бохирддоггүйн адил билиг оюуныг тунгалаг болгож чадваас бүрхэг байх үед үүсдэг, үүсэх боломж бүхий бүх зөрчил аяндаа үгүй болно гэдгийг, юмсын язгуур чанар хоосон болохыг зөв таньсан билиг оюун эрхэм болохыг илэрхийлдэг аж. Сүүлчийн **ХУМ** нь хослон барилдахыг бэлэгдэж, арга билгийн салшгүй нэгдлээр гэгээн ариунд хүрч болно гэсэн санааг агуулдаг байна. ХУМ гэдэг нь юугаар ч өөрчилж болохгүй, хөдөлшгүй, тогтвортой гэсэн үг. Арга, билгийн хослон барилдсан харилцааг хамтад нь багтаасан ойлголтын хувьд энэ утгаар ухаарах ёстой аж.

Арга, билгийн хослон барилдсан харилцаа болох зам мөрөөр замнаснаар хэн боловч өөрийн ариун бус бие, хэл, сэтгэлийг Буддагийн ариун лагшин, зарлиг, таалалын дагуу хувирган өөрчлөх боломжтойг УМ МА НИ БАД МЕ ХУМ хэмээх зургаан нийлэмж үсэг нийтдээ бэлэгдэнэ.

Энэ тарни нь гэгээрлийг өөрөөсөө ангид хайхын хэрэггүй, түүнд хүрэх боломж өөрт тань бий гэдгийг ойлгуулах зорилготой уншлага юм. Хамаг амьтан сэтгэлийнхээ мөн чанарт гэгээлэг шинжийг тээж явдаг гэж Майдар “Их хөлгөний дээд сэтгэл” (Уттаратантра) зохиолдоо айлдсан байдаг. Бид бүхэн дотооддоо хязгаарын чанадад хүрсэн нэгний мөн чанар болох гэгээрэлд хүрэх, дэвшиж ариусах чадамж, шалтгааныг тээж байдаг аж.

Таны амьдралын нэг шинэ өдөр өглөөнөөс эхлэнэ. Өдөр бүр дараах үйлийг үйлдүүштэй:

- Гахай, нохойтой адил идэж уухаа бодохоос өмнө нүүр гараа угааж, амаа цэвэрлэж, тарни уншлагаа уншууштай.
- Өнөөдөр бие, хэл, сэтгэлийн муу үйл хийхгүй гэж өөртөө хатуу хориг тавьж, муу үйл хийсэн ч, дор нь мэдэрч зогсоож, дахин үйлдэхгүй, бусдын алдааг харахгүй байхыг хичээгүүштэй.
- Ажилдаа явах, ирэх замдаа, хэн нэгнийг хүлээх, эмнэлэг, дэлгүүрт дараалалд зогсох зуураа тарни уншихад цаг хугацааг анзаарахгүй, элдэвт бухимдах зав чөлөө гарахгүй, сэтгэл тайван амгалан байхын зэрэгцээ сайн үйлээ аривуулна гэдгийг ойлгож, үүнийг хийж хэвшүүштэй.
- Галт тэрэг, нисэх онгоц, тээврийн хэрэгсэлд ч тарни уншиж явбал замын бэрхшээлийг мэдэлгүй давж, цагаа дэмий үрэхгүй, уйдаж, уур уцаар хүрэхгүй тул

тарни уншиж үйлдүүштэй.

- Шөнө унтахаар орондоо ороод өнгөрсөн өдрийн үйлийг дүгнэж, алдсан алдаагаа наминчилж (өөрөө өөртөө гэмшиж), дахиад алдахгүй байхаар өөртөө ам тангараг өгч, мөн л тарни уншлагаа уншиж дуусгаад унтууштай.

Буддын сургаал номлолын талаар гайгүй мэдлэгтэй болсон ч бусдыг юм мэддэггүй, өөрөө ганцаараа ухаантай гэж бодож, их зан, сэхүүн ааш аяг гаргадаг, хэн нэгнийг өөрөөс нь илүүг мэдвэл атаархдаг, сургаалыг сэтгэлээ ариусган цэвэрлэх хэрэгсэл болгож эс чадаж байгаа хүмүүс байдаг. Ийм хүмүүсийн оронд сургаал ном бага мэддэг ч УМ МА НИ БАД МЕ ХУМ тарнийг чин сэтгэлээсээ, итгэл бишрэлээрээ уншдаг даруу төлөв хүмүүс хавьгүй дээр аж.

### **ABSTRACT**

*This article states the problems related to the chant, its meaning, power, spirit of the chant reader beliefs, methods of interpretation and its soul.*

### **НОМ ЗҮЙ**

1. Д.Дагвадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995
2. Жамба. Тинлэй. Гэгээн гэрэл. УБ., 1999
3. Ц.Няндаг. Сурган хүмүүжүүлэх ухааны судалгаа, туршилт, үр дүн. УБ., 2006
4. Б.Оюунчимэг. Буддын сургаалыг судалж, ач тусыг нь хүртэхгүй. УБ., 2009
5. Тарнийн ёс. (2000). Улаанбаатар, Монгол.